



СОЁМБОМ ЭДЭЭ


МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№99 (99) 2021.07.27

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

ҮЙЛ ЯВДАЛ

ХОЁР ОРНЫ БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН ХАРИЛЦАА ӨРГӨЖИН ХӨГЖИЖ БУЙГ ОНЦЛОВ



БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн, Батлан хамгаалахын сайд хурандаа генерал Вэй Фөнхө өчигдөр Монгол Улсад албан ёсны айлчлал хийлээ. Айлчлал Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн, Батлан хамгаалахын сайд хурандаа генерал Вэй Фөнхө нарын албан ёсны уулзалтаар батлан хамгаалах яаманд эхэлсэн юм.

Уулзалтаар батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа, олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдал, мөн бусад харилцан сонирхсон асуудлаар ярилцаж, санал солилцлоо. Түүнчлэн хоёр улсын Батлан хамгаалах салбарын харилцаа нь Монгол, Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой болохыг сайд нар онцлон тэмдэглэж, цаашид цар тахлын нөхцөл байдал сайжирмагц цэргийн бүхий л түвшний айлчлал, солилцоо, батлан хамгаалахааюулгүй байдлын асуудлаарх зөвлөлдөх уулзалт, боловсон хүчний сургалт солилцоо, хамтарсан хээрийн сургууль зохион байгуулах зэрэг хамтын ажиллагааг үргэлжлүүлэхэд нягт хамтран ажиллахад бэлэн буйгаа илэрхийлэв.

Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр хурандаа генерал Вэй Фөнхөгийн Монгол Улсад хийсэн айлчлал нь хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа өндөр түвшинд хүрснийг тэмдэглэсэн бол БНХАУ-ын Батлан сайд хурандаа генерал Вэй Фөнхө, түүний энэ удаагийн айлчлал нь Хятад, Монголын Батлан хамгаалах салбарын харилцааг шинэ шатанд хүргэхэд чухал түлхэц үзүүлнэ гэдгийг онцлов.

Ийнхүү хүндэт зочид Батлан хамгаалах яаманд ажилласны дараа Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар бараалхав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн, Батлан хамгаалахын сайд Вэй Фөнхөг хүлээн авч буйдаа баяртай байгаагаа илэрхийлээд, БНХАУ-тай найрсаг харилцаа, бүх талын хамтын ажиллагааг тогтвортой хөгжүүлэх нь Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг бөгөөд Монгол Улсын төр, засгийн зүгээс Монгол, Хятадын Иж бүрэн түншлэлийн харилцааг улам бэхжүүлж, шинэ агуулгаар баяжуулахын төлөө идэвхтэй хамтран ажиллах бодлогыг тууштай баримталж буйгаа тэмдэглэн хэллээ.

Ноён Вэй Фөнхө, цаг гарган хүлээн авч уулзаж буй Улсын Их Хурлын даргад талархал

илэрхийлээд, БНХАУ, Монгол Улсын сайн хөршийн харилцаа, хамтын ажиллагаа тасралтгүй, амжилттай хөгжиж ирснийг тэмдэглээд ихээхэн сэтгэл хангалуун байгааг дуулгав. Тэр бээр, Төрийн тэргүүн Си Зиньпиний зөвшөөрлөөр цар тахлын үед энэхүү айлчлалыг хийж буйгаа дурдаад, хоёр улсын төрийн тэргүүн нарын харилцан тохирсныг ажил хэрэг болгон БНХАУ, Монгол Улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой байгаагаа илэрхийлсэн. Цар тахлын нөхцөлд болж байгаа энэхүү айлчлал нь хоёр талын онцгой харилцааны илэрхийлэл хэмээн үзэж буйгаа БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн, Батлан хамгаалахын сайд, хурандаа генерал Вэй Фөнхө тэмдэглэн хэллээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улс нь энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогыг тууштай явуулж, олон улс, бүс нутгийн үйл хэрэгт хувь нэмрээ оруулахыг зорьж ирснийг тэмдэглэв.

Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа нь хоёр улсын харилцааны чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд улс төрийн харилцаа, харилцан ойлголцлыг бэхжүүлэхтэй шууд холбоотой байдгийг мөн онцлон дурдав.

Монгол Улсын "Ковид-19" цар тахлын халдвартай тэмцэх хүч чармайлтад БНХАУ-ын зүгээс үнэтэй дэмжлэг үзүүлж, эмнэлгийн хэрэгсэл, эд материал болон вакцины олон удаагийн тусламж үзүүлсэн, түүний дотор БНХАУ-ын Батлан хамгаалах яамны шугамаар вакцины тусламж үзүүлсэнд талархал илэрхийлэв. БНХАУ-д үйлдвэрлэсэн вакцинаар хүн амынхаа дийлэнх хувийг богино хугацаанд вакцинд хамруулсан нь "Ковид-19"-ийн тархалт, эрсдэлийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэснийг Г.Занданшатар дарга уулзалтын үеэр онцлон тэмдэглэлээ.

Уулзалтад Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Монгол Улсаас БНХАУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Т.Бадрал, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг, БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Чай Вэнрүй, Цэргийн төв Зөвлөлийн Тамгын газрын орлогч дарга, хошууч генерал Фен Мижунь, Шинжааны цэргийн тойргийн орлогч командлагч, хошууч генерал Яан Линь, Олон улсын цэргийн хамтын ажиллагааны газрын орлогч дарга, хошууч генерал Сун Яаньчао нар болон албаны бусад хүмүүс байлцлаа.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 23	🌧️ 10

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 29	🌧️ 22

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 39	🌧️ 22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.847.0	2.850.0
EUR 🇪🇺	3.365.0	3.375.0
CNY 🇨🇳	439.5	441.2
RUB 🇷🇺	39.10	39.70
JPY 🇯🇵	25.45	26.02
KRW 🇰🇷	2.38	2.52

ЗУРХАЙ

2021.07.27, /МЯГМАР ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 19

ЗУНЫ АДАГ ХӨХӨГЧИН ХОНЬ САРЫН ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ, УЛААН ХУЛГАНА ӨДӨР.

Үс засуулбал:
Сайн нөхөртэй
Нөхөрлөнө
Наран ургах, шингэх:
05:22-19:33

Барилдлага:
Арвидаж
Шүтэн барилдлага:
Төрөн түгэхүй
Суудал:
Гал

Өнөөдөр Аргын тооллын долдугаар сарын 27, Ангараг гараг. Билгийн тооллын 19, шувуун хошуут одтой өдөр.

Энэ өдөр үс засуулбал сайн нөхөртэй нөхөрлөнө.

Наран ургах цаг 05:22, наран шингэх нь 19:33 цаг. Өдрийн барилдлага арвидаж бол шүтэн барилдлага нь төрөн түгэхүй юм. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогосод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад "Сайн нөхөртэй учрах" хэмээн сайн.

Мөн энэ өдөр луу жилтнээ аливаа үйл бүтээхэд эерэг сайн бол бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд, хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, хүү сангийн эх хатгах, эд агуурс авах, урлан бүтээхэд сайн. Харин улаа гаргах, хиншүү хярвас гаргах, төлөө тавих, морь уралдахад муу.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 157.974 +1249	ЭДГЭРСЭН 154.172 +2014	НАС БАРСАН 782 +8
--	----------------------------------	-----------------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 4012 +71	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 262 +14	ЭДГЭРСЭН 3677 +32
------------------------------------	---------------------------------------	-----------------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 195,310,474
Эдгэрсэн Нийт: 177,102,067
Нас барсан Нийт: 4,181,982

ДЕЛЬТА ХУВИЛБАР АНХЛАРАХ ШИНЭ ШИНЖ ТЭМДЭГ

Сүүлгах, Хамар битүүрэх, нус гоожиж, Булчин өвдөх, Урт хугацаагаар толгой өвдөх, Бөөлжих, Хоолой өвдөх, Бие тавгүйрэх, идэрх.

ДЭЭРХ ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРВЭЛ ШИНЖИЛГЭЭ ӨГӨӨРЭЙ.

ЦАГ ҮЕ



Хүн төрөлхтний баяр цэнгэл ТОКИО-2020 Олимпын XXXII наадам энэ сарын 23-нд эхлээд байна. Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний нэрийн өмнөөс тус наадамд спортын 7 төрлөөр 12 тамирчин эрх аван оролцож байна.

Тус наадамд Монгол Улс оролцож эхэлснээс хойш Зэвсэгт хүчний Алдар спорт хорооны тамирчид тасралтгүй оролцсон байдаг бөгөөд Олимпын наадмын мөнгө, хүрэл, шагналт байрыг нийт 13 тамирчин хүртсэн байна. Зэвсэгт хүчний төлөөлөл нийт тамирчин дайчиддаа амжилтын дээдийг хүсэн ерөөе.

ХОТЫН ТӨВД 06.00 ЦАГТ НЭЭГДЭХ, АВТОМАШИНГҮЙ “ӨГЛӨӨНИЙ ГУДАМЖ” НЭЭГДЛЭЭ



Монгол Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ өглөөний цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх “Эртэч Монгол” уриалгыг гаргасан билээ. Үүний дагуу төрийн байгууллагуудын ажил 08.00 цагт эхлэхээр болсон юм. Тэгвэл талбайн баруун талын “Гутлын 22” гудамжийг “Өглөөний гудамж” болгон тохижуулж, өчигдөр өглөөнөөс үйл ажиллагаагаа эхлүүлээ.

Улсын Л.Оюун-Эрдэнэ өглөөний цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх “Эртэч Монгол” уриалгыг гаргасан билээ. Үүний дагуу төрийн байгууллагуудын ажил 08.00 цагт эхлэхээр болсон юм. Тэгвэл талбайн баруун талын “Гутлын 22” гудамжийг “Өглөөний гудамж” болгон тохижуулж, өчигдөр өглөөнөөс үйл ажиллагаагаа эхлүүлээ.

Газар, үсчин зэрэг “Гутлын 22” гудамжинд байрлаж байсан бүх үйл ажиллагааны газрууд өглөөний 06.00 цагаас үйлчилгээ үзүүлэх аж. “Өглөөний гудамж”-ийг жишиг болгон Улаанбаатар хотын бүх дүүрэгт зохион байгуулах чиглэлийг дүүргийн захиргаанд өгөхөөр болсон байна. Ингэснээр Улаанбаатар хотын иргэд өглөөний идэвхтэй амьдралтай болно гэж үзэж байгаа юм.

Номтой кафе, кофе шоп, ресторан, цайны

Тус гудамжийг

КОВИД-19 ХАЛДВАРААР ӨВДӨӨД ЭДГЭРСНИЙ ДАРААХ ЗӨВЛӨМЖ



Амин дэмээр баялаг хоол хүнс, шингэн зүйл сайн хэрэглээрэй

бол эдгэрснийхээ дараа тамхинаас татгалзаарай. Архи согтууруулах ундаанаас мөн адил татгалзаарай.

гүнзгий амьсгал авч гаргах амьсгалын дасгал хийж уушгины үйл ажиллагаагаа дэмжээрэй.

Ажил амралтын зохицуулалт хийж хангалттай амарснаар хурдан эдгэх боломжтой.Өөртөө хэт их ажлын ачаалал битгий өгөөрэй.

Хэвтэж эсвэл унтаж байхдаа доошоо эсвэл хажуу байрлалаар унтахыг хичээгээрэй. Ингэснээр таны уушгины үйл ажиллагаа илүү хурдан нөхөн сэргэхэд ач тустай

Хэрэв танд КОВИД-19-тэй холбоотой эрүүл мэндийн асуудал байвал нэгдсэн лавлах 119 эсвэл харьяа өрхийн эрүүд мэндийн ажилтнаас зөвлөгөө мэдээлэл аварай.

Ханиаж найтаахдаа ам, хамраа таглаж бусдад халдвар дамжихаас сэргийлээрэй Алхах , суниах ,иог хийх өөрийн биеийн онцлогт тохирсон дасгал хөдөлгөөнийг хийж хэвшүүлээрэй.

ҮЙЛ ЯВДАЛ

АХЛАХ АХЛАГЧ Э.ДАВААЖАМЦ ХЭТ ХОЛЫН ГҮЙЛТИЙГ АМЖИЛТТАЙ ТУУЛЖ ТӨРӨЛХ НУТАГТАА ИРЛЭЭ



Ардын Хатанбаатар Магсаржавын нэрэмжит, Цэргийн гавьяаны улаан тугийн одонт, Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн хөгжимчин, ахлах ахлагч Э.Даваажамц Монголын баруун хязгаар Ховд аймгийн Ард Аюушийн талбайгаас монгол төрийн далбаагаа үүрээд хэт холын зайн гүйлтийг 2021 оны 6 дугаар сарын 2-ны өдөр

эхлүүлсэн. Тэрээр зүүн хязгаарын Дорнод аймаг хүртэл 2127 км замыг нийт 46 хоног туулж холын зайн гүйлтийн рекордыг ийнхүү эвдэж өчигдөр төрөлх нутагтаа уухайлан очив. Түүнийг аймгийн удирдлагууд, Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн бие бүрэлдэхүүн, Ховдын ард иргэд

ёслол хүндэтгэлтэйгээр хүлээж авлаа. Аймгийн удирдлагуудын зүгээс Э.Даваажамцын гэр бүлийг 2 өрөө байраар шагнаж, хамт явсан багийн гишүүд тус бүрд 1 сая төгрөгийн урамшуулал олгосон бол Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч хурандаа Х.Энхболд 10 хоногийн цалинтай чөлөөг олголоо.

ЦАХИМ ШУУДАНД

ӨРГӨӨ ЦАГААН ГЭР БЭЛЭГЛЭВ



Зэвсэгт хүчний 110 дугаар анги

Ангийн удирдлага, ахлагчийн зөвлөл, Орхон аймгийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штабтай хамтран цэргийн алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд Зэвсэгт хүчний 110 дугаар ангийн Барилга угсралт засварын ротын

засал чимэглэлчин, ахлагч Б.Батбөхэд их таван ханатай өргөө цагаан гэрийг гардуулан өглөө. Тус арга хэмжээнд ЗХЖШ-ын Сургалтын бодлого зохицуулалтын хэлтсийн дарга хурандаа Ш.Гантулга, тэргүүн ахлагч Т.Гантөмөр, Орхон аймгийн

цэргийн штабын дарга, дэд хурандаа Б.Оюунтүгшүүр, ангийн удирдлага, ахлагчийн зөвлөлийн гишүүд оролцлоо. Энэ үеэр ахлагч Б.Батбөхэд баяр хүргэн цаашдын ажил хөдөлмөрт нь өндөр амжилт хүсэн ерөөж хурандаа Ш.Гантулга гэрийн номын сан бэлэглэсэн юм.

УРИАЛГА

Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн ахлах ахлагч, Үндэсний шигшээ багийн тамирчин, хөнгөн атлетикийн марафон гүйлтийн олон улсын хэмжээний мастер Цэвэррадэнгийн Бямбажав Япон Кириширо аймгийн Ойтад 2020 оны хоёрдугаар сарын 2-нд болсон 64 дэх удаатгийн уламжлалт "Беппу-Ойта" олон улсын марафонд хүрд хрээд сорин уралдаж, 2 цаг 09 минут 05 секундын амжилтаар V байр эзлэн "ТОКИО-2020" зуны олимпын 32 дугаар наадамд марафон гүйлтийн төрлөөр эх орноо төлөөлөн оролцох эрхээ авад байгаа билээ.

Ахлах ахлагч Ц.Бямбажав цэргийн хрний тэсвэр хатуужил, бие бялдрын өндөр бэлтгэлжилт, хүрд хрчийг харуулж, эх орон, Зэвсэгт хүчин, Алдарын цэргийн алдар хрндийг тив, дэлхийд цуграйтуулах зорилго тэмцрэлтэйгээр бэлтгэл сургуулилтаа амжилттай базааж, ирэх сарын 2-ны өдөр эх орноосоо мордох гэж байна.

Цөмд ахлах ахлагч Ц.Бямбажавыг "ТОКИО-2020" зуны олимпын 32 дугаар наадамд марафон гүйлтийн төрлөөр эх орноо төлөөлөн оролцоход шаардлагатай санхржилтийг нь брдррлах хрээнд "Этгээлийн дэмжлэл" хандив өргөхийг Зэвсэгт хүчний Алдарын цэргийн нийт бие бррдэхрнрээ уриалж байна.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ ХОШУУЧ ГЕНЕРАЛ О.ЭНХБАЯР

Улаанбаатар хот 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдөр

Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ Батлан хамгаалах яам Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС "Соёмбо" сонин

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ. * Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхтэй, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ. * Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Оффисуудын ордон Индекс: 10018 Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)